

## 13

**МЭРГЭЖЛИЙН /НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ/ АНГЛИ ХЭЛНИЙ  
ШИНЭЧИЛСЭН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛЖ ТУРШСАН  
БАЙДАЛ**

Л.Энхмэнд

**Abstract**

The paper examines how construction and use of the new curriculum of ESP/Accounting English/ in formal instruction may influence students' achievement in mastering professional English, as perceived by L2 learners at the School of Economic Studies NUM. in Mongolia. The focus is on learner perception of their own experience. The methodology used was both qualitative, responding to a questionnaire and interview, and quantitative, involving exam results. The data elicited is analyzed to construct a differentiated picture of teaching ESP with the new curriculum in actual practice.

*Түлхүүр үгс: хичээлийн агуулга, мэргэжлийн чиглэл, практик хэрэглээ, сургалтын технологи, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, мэргэжлийн Англи хэл, санал асуулга, нягтлан бодох бүртгэлийн үндсэн нэр томъёо, судалгаа, орчуулга хийх чадвар, хичээлийн зорилго, практик ач холбогдол*

Дэлхийн олон хэлнүүд дотроос өнөө үед Англи хэл онцгой байр суурь эзэлж түүний нөлөө, ач холбогдол улам бүр өсч байгаа бөгөөд дэлхийн 55 орон уг хэлийг төрийн албан ёсны хэл хэмээн үзэж байна. Түүнчлэн манай гаригийн интернет мэдээллийн 70 орчим хувь болон дэлхийн шилдэг 500 гаруй их, дээд сургууль англи хэлээр үйл ажиллагаа явуулж, гэрээ, хэлэлцээрийн дийлэнх нь англи хэл дээр хийгдэн улс хоорондын болон олон улсын түвшинд англи хэлний гүйцэтгэх үүрэг, хэрэглээ эрс өсч байна. Үүнтэй уялдан Англи хэлний практик хэрэглээг улам нэмэгдүүлэх зорилгоор багш нар орчин үеийн сургалтын технологи ашиглах, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг сургууль болон суралцагчдынхаа онцлогт тохируулан боловсруулж хэрэгжүүлэх ажлыг байнга хийж байх шаардлагатай болж байна.

2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн МУИС-н ЭЗС нь Канадын Сургалтын Академитай хамтран “Компьютержсэн нягтлан бодох бүртгэл”-ийн (Basic Bookkeeping Level I, II) сургалт зохион байгуулж байгаа билээ. Энэ

сургалтанд зөвхөн МУИС-н ЭЗС-д суралцаж буй оюутан, магистрантуудаас гадна өөр сургуулийн оюутнууд болон бизнесийн салбарт ажиллаж буй хүмүүс хамрагдаж байна. Сургалтын эхний шатанд 16 цагийн Нягтлан бодох бүртгэлийн Англи хэлний хичээлийг АХТ-н багш нар зааж байгаа юм. Сургалтын явцаас харахад уг хичээлийн агуулгыг мэргэжлийн чиглэлийн практик хэрэглээнд нийцүүлэх шаардлагатай байгаа бөгөөд хичээлийг улам сонирхолтой болгох оюутнуудын хэрэгцээ, хүсэлд тохирсон шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулах нь зайлшгүй болжээ.

Түүнчлэн 2008 оны 10-12 сард хийгдсэн “МУИС-ийн ЭЗС-ийн бакалаврын сургалтын өнөөгийн байдал” тайлангийн хүрээнд хийсэн ажил олгогчдын судалгаанд төрийн болон бизнесийн 33 байгууллагын удирдлага болон дээд түвшний менежерүүдийг хамруулсан бөгөөд шинээр төгсөн ирж буй мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварт оролцогчдын зүгээс өгсөн үнэлгээний хүснэгтийг харуулбал:

Шалгуур	Хангалттай	Хувь	Дунд зэрэг	Хувь	Хангалтгүй	Хувь	Нийт
Тухайн ажлын байранд шаардагдах гадаад хэлний мэдлэг, харилцааны соёл	7	21,2	21	63,6	5	15,2	33

Эндээс харахад хангалттай гэсэн үнэлгээг хамгийн бага өгсөн шалгуур үзүүлэлт бол гадаад хэлний мэдлэг, харилцааны ур чадвар юм. Энэ үзүүлэлтээр оролцогчдын дөнгөж 21.2% нь хангалттай гэсэн бол мөн л хамгийн өндөр үзүүлэлт болох 63.6% нь дунд зэрэг, 15.2% нь хангалтгүй гэж үзжээ. Түүнчлэн оролцогчдын зүгээс эдийн засгийн боловсрол олгодог Их дээд, сургуулиудийн сургалтын хөтөлбөрт анхаарвал зохих доорх саналуудыг дэвшүүлсний дотор сургалтын хөтөлбөрөө дэлхийн жишигт нийцүүлэн ойр ойрхон шинэчилж байх, мэргэжлийн Англи хэлний мэдлэгийг түлхүү оруулах асуудлуудыг тус тус оруулжээ.

Энэ нь ЭЗС-н сургалтанд хэрэглэж байгаа Англи хэлний хичээлийн хөтөлбөрийг шинэчилэн өнөөгийн зах зээлийн хэрэгцээнд тохируулан сургалтын практикт нэвтрүүлэх шаардлагатай байгааг илтгэн харуулж байна.

2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн “Нягтлан бодох бүртгэлийн Англи хэл” хичээлийн хөтөлбөрийг боловсруулж 2009 оны 1 сараас эхлэн 5 ангийн 100 гаруй оюутнуудад заасан бөгөөд сургалтын эцэст шинэчилсэн хөтөлбөрийн талаар оюутнуудаас санал асуулга авч цаашид сайжруулан боловсронгуй болгох ажлыг хийж байна.

Шинэчилсэн хөтөлбөрийн дагуу “Нягтлан бодох бүртгэлийн Англи хэл” хичээлийн агуулгын хувьд логик уялдаа холбоо бүхий текстүүдийг сэдэвчилсэн

хэлбэрээр “Power Point” програмд оруулан тайлбарлаж, орчуулан заах нь зөвхөн багшийн хувьд үр дүнтэй хялбар төдийгүй оюутнуудад сонирхолтой ойлгоход дөхөм болж байгааг хэлэх хэрэгтэй.

### Судалгаа:

Судалгааны төлөвлөгөө, загвар, асуулгын эхний хувилбарыг боловсруулан эхний судалгааг 2008 оны 2 сард нийт дүнгээр 80 гаруй оюутнуудаас авч цуглуулсан асуулгын хуудсуудыг хянан засварлан нөхсөн асуулгын хуудсуудыг компьютерт шивэх болон мэдээлэл боловсруулалт хийх ажлыг Матемтик Статистикийн боловсруулалт хийх SPSS програмыг ашиглан гүйцэтгэж Excel програмаар оюутнуудын шалгалтын дүнд анализ хийлээ.

### Судалгаанд хамрагдалт:

Уг судалгаанд ЭЗС-н Санхүү -36 ангийн 22 /28,6%/, ЭЗО- 3 ангийн 21 /27,3%/, Менежмент 3а ангийн 17 /22,1%/ болон НББ-н 2,5 жилийн 2 курсын 16 /22,1%/ оюутнуудыг хамруулсан.

### Судалгаанд хамрагсдын ерөнхий шинж:

Энэ хэсэгт бид судалгаанд хамрагсдын насны бүлэг болон энэ сургалтанд хамрагдахаас өмнө Нягтлан бодох бүртгэлийн үндсэн нэр томъёонуудын англи орчуулгыг хийх хэмжээний мэдлэгтэй байсан эсэх зэргийг гаргалаа.

### Насны бүлэг

	Frequency	Percent
19-20 насны	45	58,5%
21-22 насны	16	20,8%
23-25 насны	11	14,3%
26-28 насны	3	3,9%
30-с дээш	2	2,6%

Та энэ хичээлийг судлахаас өмнө НББ-н нэр томъёонуудыг орчуулах хэмжээний мэдлэгтэй байсан уу?

	Frequency	Percent
Тийм	<b>22</b>	<b>28.6</b>
Бага зэрэг	21	27.3
Үгүй	<b>17</b>	<b>22.1</b>
Total	77	100.0

Судалгаанд хамрагдсан 77 оюутны 61- 79% нь өдрийн ангийн 19-22 насны бусад нь НББ-н 2,5 жилийн ангийн 23-34 насны оюутнууд байсан.

Түүнчлэн 22 оюутан буюу 28,6% нь энэ хичээлийг судлахаас өмнө НББ-н нэр томъёонуудыг орчуулах хэмжээний мэдлэгтэй гэж хариулсан байхад бараг 50 гаруй хувь нь бага зэрэг орчуулж чаддаг болон орчуулга хийх хэмжээний мэдлэггүй байсан гэж хариулжээ. Эндээс харахад НББ- 2,5 жилийн ангид суралцдаг оюутнууд нь өмнө нь Их Дээд сургуулийг Бакалавр зэрэгтэй төгссөн байсан учраас харьцангуй бусад оюутнуудаас илүү мэргэжлийн үг хэллэг мэддэг, орчуулга хийх чадвартай байсан бөгөөд бусад өдрийн ангийн оюутнуудын зарим нь Англи хэлний дунд болон дундаас дээш шатны мэдлэгтэй байсан нь бас нөлөөлж байна. Түүнээс гадна бусад оюутнууд мэргэжлийн үг хэллэгийн орчуулгыг ойлгомжтой хялбар хэлбэрээр заалгаснаар НББ-н дараагийн шатны сургалтанд амжилт үзүүлэх нь дамжиггүй.

**Судалгааны дүн:**

**Хүснэгт- 1**

	Тухайн хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийн агуулга танд ойлгомжтой байсан		Багш сургалтын шинэ арга зүйг ашигласан гэж үзэж байна	
	Frequency	Percent	Frequency	Percent
Тийм	37	48.1	57	74.0
Бага зэрэг	33	42.9	18	23.4
Үгүй	7	9.1	2	2.6
Total	77	100.0	77	100.0

Сургалтын шинэ хөтөлбөрийн дагуу Power Point програм ашиглан уг хичээлийн гол агуулгыг мэргэжлийн чиглэлийн практик хэрэглээнд нийцүүлэн хамгийн түгээмэл хэрэглээний үг хэллэгүүдийг НББ-н гол гол тайлангууд болох тайлан баланс, орлогын тайлан, шалгах баланс, ажлын дэвтэр зэргүүдэд яаж хэрэглэгддэгийг бодитойгоор харуулан орчуулан тайлбарлав. Оюутнуудын 48,1% нь хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийн агуулга ойлгомжтой байсан гэж хариулсан байхад 7 оюутан буюу 9,1% нь ойлгоогүй байна. Энэ нь хичээлийг ойлгоогүй гэсэн санаа биш харин шинэ хөтөлбөрөөр зааж байсныг мэдээгүй байсантай холбоотой болов уу. Дийлэнх буюу 74% нь багшийг сургалтын шинэ арга зүйг ашиглан заасан гэсэн нь хичээлийг ойлгомжтой хялбар болгох гэсэн зорилго биелсэн гэж үзэж байна.

Хүснэгт -2

	Хичээлийн зорилго ойлгомжтой байсан		Хичээлийн практик ач холбогдол тодорхой байсан	
	Frequency	Percent	Frequency	Percent
Огт санал нийлэхгүй байна	<b>1</b>	<b>1.3</b>	<b>3</b>	<b>3.9</b>
Цөөн зүйлтэй санал нийлж байна	12	15.6	8	10.4
Ихэнхтэй нь санал нийлж байна	28	36.4	<b>45</b>	<b>58.4</b>
Бүрэн санал нийлж байна	<b>36</b>	<b>46.8</b>	21	27.3
Total	77	100.0	77	100.0

Уг хичээлийн зорилго ойлгомжтой байсан гэж 83,2% нь, харин практик ач холбогдолын тухайд 58,4% нь тодорхой байсан гэж үзжээ. Оюутнуудын хувьд “Компьютержсэн нягтлан бодох бүртгэл”-ийн хичээлд хамрагдаж 2 шатны сургалт болон шалгалтын дараа амжилттай суралцсан оюутнууд сертификаттай төгсөх учраас хичээлийн зорилго, практик ач холбогдол тэдний хувьд тодорхой байсан байна.

Хүснэгт -3

Энэ хичээлийг судалсанаар таны мэргэжлийн Англи хэлний мэдлэг дээшилсэн үү?

	Маш их	Хангалттай	Бага зэрэг	Total
Санхүү-3б	1	<b>7</b>	14	22
	1.3%	<b>9.1%</b>	18.2%	28.6%
Эдийн Засгийн онол-3	1	<b>10</b>	10	21
	1.3%	<b>13.0%</b>	13.0%	27.3%
Менежмент-3б	1	<b>11</b>	5	17
	1.3%	<b>14.3%</b>	6.5%	22.1%
НББ-2.5 жил-2	1	<b>9</b>	7	17
	1.3%	<b>11.7%</b>	9.1%	22.1%
<b>Total</b>	4	<b>37</b>	36	77
	5,2%	<b>48,1%</b>	46,8%	100,0%

Энэхүү хичээлийн хамгийн гол зорилго нь шинэчилсэн хөтөлбөр боловсруулан сургалтын явцыг үр дүнтэй болгосноор оюутнуудын мэргэжлийн Англи хэлний мэдлэгийг дээшлүүлж НББ-н мэргэжлийн сэдвүүд болон Англи хэл дээр хийгдсэн НББ-н тайлан балансруудыг уншиж ойлгох, өөрсдөө бие даан тайлан балансыг Англи хэл дээр хийлгэх, гол гол нэр томъёонуудын тайлбарууд болон

бусад эх үүсвэрүүдээс хэрэгтэй мэдээллийг авч орчуулж сургах дадлыг олгуулах явдал байсан. Үүнтэй уялдан уг хөтөлбөрийн хувьд оюутнуудын мэргэжлийн Англи хэлний мэдлэгийг дээшилсэн эсэх асуудал чухал байсан. Судалгаанаас харахад 37 оюутан буюу 48,1% нь Хангалттай сайн сурсан гэсэн хариулт өгсөн нь сургалт ажилттай болсныг харуулж байна. 36 оюутан буюу 46,8% нь бага зэрэг сурсан гэсэн нь огт мэргэжлийн үг хэллэг мэддэггүй байсан оюутнуудын хувьд боломжийн үзүүлэлт байна. Нийт оюутнуудын 53,3% нь олж авсан мэдлэгтээ сэтгэл хангалуун байна.

#### Хүснэгт -4

Энэ хичээл нь миний эзэмшиж буй мэргэжилтэй чухал холбоотой

	Огт санал нийлэхгүй байна	Цөөн зүйлтэй санал нийлж байна	Ихэнхтэй нь санал нийлж байна	Бүрэн санал нийлж байна	Total
Санхүү-3б	0	5	9	<b>8</b>	22
	.0%	6.5%	11.7%	<b>10.4%</b>	28,6%
Эдийн Засгийн онол-3	5	4	7	<b>5</b>	21
	6.5%	5.2%	9.1%	<b>6.5%</b>	27,3%
Менежмент-3б	0	8	0	<b>9</b>	17
	.0%	10.4%	.0%	<b>11.7%</b>	22,1%
НББ-2.5 жил-2	0	0	0	<b>17</b>	17
	.0%	.0%	.0%	<b>22.1%</b>	22,1%
Total	5	17	16	<b>39</b>	77
	6.5%	22.1%	20.8%	<b>50.6%</b>	100,0%


НББ-н Англи хэл хичээл нь нийт оюутнуудын 50,6 хувьд тэдний эзэмшиж буй мэргэжилтэй чухал холбоотой гэж үзжээ. Тэдний дийлэнх нь НББ, санхүүгийн мэргэжлээр сурч байгаагаас гадна Менежментийн ангийн 9 оюутан мэргэжилтэйгээ чухал холбоотой гэж хариулсан байна.

#### Хүснэгт -5

Тухайн хичээлийн агуулга хүнд санагдсан	Шалгалтын агуулга заасан хичээлтэй уялдаатай байсан			
	Frequency	Percent	Frequency	Percent
Огт санал нийлэхгүй байна	17	22.1	2	2.6
Цөөн зүйлтэй санал нийлж байна	31	40.3	5	6.5


Ихэнхтэй нь санал нийлж байна	23	29.9	30	39.0
Бүрэн санал нийлж байна	6	7.8	40	51.9
Total	77	100.0	77	100.0

НББ-н Англи хэл хичээлийн 16 цагийн эцэст НББ нэр томъёонуудын тайлбарыг англи хэлнээс орчуулах болон жишээ Тайлан баланс болон Ашиг Орлогын тайлангаас тодорхой утгуудыг сонгон авч даалгаврыг нөхөх 50 онооны шалгалтыг нийт 113 оюутнаас авч дүгнэн анализ хийлээ. Судалгаанд оролцсон 77 оюутнаас гадна ЭЗС-н НББ –н Магистрын эчнээ 2-р ангийн 13 оюутан болон Мандах Бүртгэл Дээд сургуулийн НББ –н 3-р ангийн 21 оюутнууд сургалтанд хамрагдаж шалгалт өгсөн. Шалгалтын дүнг харуулбал:



A-10  
B-26  
C-33  
D-26  
F-18

Анги тус бүрээр амжилт чанарыг гаргавал:



	Санхүү 3Б	ЭЗО 3	менежмент 3А	НББ 2,5 жил 2	НББ Магистр эчнээ	Мандах НББ-3
■ Чанар	56%	9.50%	11.70%	62.50%	46.00%	9.50%
■ Амжилт	88%	66.60%	64.70%	100%	84.00%	100%

Эндээс харахад НББ-н 2,5 жилийн 2-р ангийн оюутнууд хамгийн өндөр амжилт үзүүлсэн бол ЭЗО-3 анги тааруу дүнтэй гарчээ. Мөн мэргэжлийн НББ анги болох Мандах Бүртгэл Дээд сургуулийн 3 ангийн 21 оюутан сайн дүн үзүүлээгүй нь тэд 3 жилийн турш Үндсэн Англи хэлийг Ахисан түвшинд хүртэл суралцаж байгаа боловч мэргэжлийн Англи хэл огт заалгаж байгаагүйтэй холбоотой болов уу гэж үзэж байна. Түүнчлэн ихэнх оюутнуудын хувьд мэргэжлийн НББ-н нэр томъёонуудын тайлбаруудыг Англи хэлнээс орчуулга хийх нь нилээд хүнд байсан байж болно. Учир нь оюутнууд үндсэн Англи хэл болон бизнесийн Англи хэлний хичээлийн шалгалтыг асуултанд хариулах, хэл зүйн дүрмийн даалгаварууд болон сэдвийг уншиж дутуу бичигдсэн үг хэллэгүүдийг нөхөх зэрэг уншиж ойлгох ур чадвар шаардсан ажлыг гүйцэтгэж өгдөг байснаас орчуулга хийж мэдлэгээ шалгуулан дүгнүүлдэггүй байсан. Зарим өгүүлбэрүүд англи хэлнээ буухад төвөгтэй байсныг дараа дараагийн шалгалтын асуултын зохиохдоо анхаарч засах болно.

Түүнээс гадна 29 оюутан буюу 37,7% нь тухайн хичээлийн агуулга зарим талаар хүнд санагдсан гэж хариулсан нь мэргэжлийн сэдвүүд болон тайлан баланс зэрэг бусад гол гол тайлангууд дахь Англи тайлбаруудыг орчуулан тайлбарлаж байсан нь зарим талаар багшид ч хүндхэн байсныг тэмдэглэх хэрэгтэй. 17 оюутанд хичээл хүнд биш байсан байна. Шалгалтын агуулга заасан хичээлтэй уялдаатай байсан талаархи оюутнуудын хариултаас харахад 40 оюутан буюу нийт асуулгад оролцогчдын 51,9% нь уялдаатай байсан гэжээ. Тиймээс шалгалтын асуултууд хичээлтэй холбоотой байсан боловч орчуулах өгүүлбэрүүдийг зөв сонгох болон бусад даалгаврыг нарийн сонгох хэрэгтэй байна.

#### Дүгнэлт:

- Хэдийгээр НББ-н Англи хэлний цаг цөөхөн боловч зөв хөтөлбөрөөр шинэлэг арга зүй ашиглан хичээлийг заавал оюутнуудын мэргэжлийн Англи хэлний мэдлэгийг дээшлүүлэн хичээлийг үр дүнтэй болгох боломжтой.
- Бизнесийн Англи хэлний хичээл дээр орчуулгыг түлхүү оруулж орчуулга хийх арга зүйг сайн зааж оюутнуудаар бие даалган сайн хийлгэх хэрэгтэй байна.
- Цаашид шинэ хөтөлбөрийг улам боловсронгй болгон on-line хэлбэрээр сургалт явуулах ажлыг эхлүүлэх
- Шалгалтын асуулт болон бусад даалгаврыг бэлтгэхдээ суралцагсдын мэргэжлийн онцлог болон эчнээ, оройн, Магистрын ангийн оюутнуудын хувьд бага зэрэг ялгавартай хандах



**Ашигласан ном зүй:**

1. “МУИС-ийн ЭЗС-ийн бакалаврын сургалтын өнөөгийн байдал” тайлан  
2008
2. Д. Чимгээ *SPSS for Windows Хэрэглэгчийн гарын авлага*  
Улаанбаатар 2008
3. Д.Энхбаатар *Microsoft Excel 2003-н томъёо, функцууд*  
Улаанбаатар 2007
4. К.О’Sullivan *English Language Development. Third Education Development  
Project* Ulaanbaatar 2008
5. Price Haddock Brock *College Accounting* Mc Grow Hill Irwin 200
6. Micheal R. Sneyd *Accounting Professional Reading Series*  
Prentice Hall International 1994